УЛАМЖЛАЛТ АНАГААХ УХААН

Монголын уламжлалт анагаах ухаан дахь Халдварт өвчний ангиллыг тодруулах нь

Дагвадорж Ц.[1], Дармаа М.[1], Болд Ш.[1,2]

[1]"Ач" Анагаах ухааны их сургууль
[2]Эм зүйн шинжлэх ухааны их сургууль,

Abstract

A Study on infectious diseases was classified in Mongolian Traditional Medicine

Dagvadorj Tserendorj[1], Darmaa Munkhdorj[1], Bold Sharav[1,2]

[1]"Ach" Medical University, Mongolia
[2]Mongolian University of Pharmaceutical Sciences, Mongolia,
Correspondence: Bold Sharav, Mongolian University of Pharmaceutical Sciences, Mongolia.
Email: boldshrv@gmail.com

Background

In Mongolia, scholarly lamas and doctors have reclassified infectious diseases that are not found in India or Tibetan medicine but are common among Mongolians, in accordance with the theories of wind, bile, and phlegm. One clear example is the scriptures that systematically classify, terminology, diagnose, and treat infectious diseases. We have conducted this research to examine some sources, documents, and medical texts related to the history of infectious disease classification and to disseminate it for research and training, and to ensure public accessibility.

Objective

The research objective is to study how infectious diseases were classified in ancient medical texts.

Methods

This study utilized source analysis of ancient texts and the checklist method as research methods.

Conclusion: The prominent Mongolian Buddhist and medical figures, Lamyn Gegeen Luvsandanzanjantsan, in his sutra "Man ngag bdud rtsi zegs ma," "Man ngag rin chen 'byung gnas" by Jambalchoijidanzanperenlei, and "Bdud rtsi zil dkar" by Sumbe Khamba Ishbaljir, consider that infectious diseases are caused by certain bacteria. According to the sources preserved in Mongolia related to infectious diseases, Mongolian ancient doctors and scholar-lamas have greatly enriched the information and facts about infectious diseases. At the same time, they have discovered new infectious diseases that are not found in Indian and Tibetan medical books but are common in Mongolia, and have enriched the classification of infectious diseases.

Keywords: ancient doctors, infectious disease, infectious classification, scriptures, Mongolian doctors.

Pp 60-66, References 18

Үндэслэл

Халдварт өвчнийг ангилах нь тархвар судлал, оношилгоо, эмчилгээ, хариу арга хэмжээний гол үндэс тул маш чухал ач холбогдолтой байдаг. Халдварт өвчний талаарх мэдлэг хуримтлагдаж, шинээр олон төрлийн халдварт өвчин бүртгэгдэх болсон. Ингэснээр халдварт өвчнийг үүсгэж байгаа эмгэгтөрүүлэгчийн шинж чанар, эмнэлзүй болон тархвар судлалын төлөв байдал, ач холбогдлоор нь системчлэн ангилах шаардлага үүссэн. Энэ дагуу олон орны эрдэмтэд төрөл бүрийн зарчимд суурилсан халдварт өвчний олон ангиллыг санал болгосон байдаг. Өвчин эмгэгийг системтэйгээр ангилах анхны оролдлогууд 1600-1700-аад онд хийж байсан. Гэвч өвчний нэр томьёоны зөрчил, статистикийн мэдээлэл хомс байсантай холбоотой өвчнийг ангилах нь ашиг тус багатай гэж олон оронд үзэж байжээ. 1800-аад оны үеэс өвчнийг ангилах нэгдсэн тогтолцоо бий болгох нь чухал ач холбогдолтойг ойлгож, олон улсын статистикийн хүрээлэн 1893 онд анх өвчний олон улсын ангиллыг баталсан байна. Энэ систем нь Францын статистикч, хүн ам зүйч Жак Бертильоны боловсруулсан үхлийн шалтгааны ангилалд үндэслэсэн юм [1]. 1898 онд Америкийн Нийгмийн эрүүл мэндийн нийгэмлэгээс Канад, Мексик, АНУ-д энэ системийг ашиглахыг зөвлөж, арван жил тутам шинэчилж байхыг зөвлөжээ. Дараа жилүүдээс нь Бертильоны ангиллыг олон улсын үхлийн шалтгааны жагсаалт, эцэст нь Өвчний олон улсын ангилал гэж нэрлэх болсон. 1948 оноос Дэлхийн эрүүл мэндийн байгууллага (ДЭМБ) өвчний олон улсын ангиллалыг хэвлэн нийтлэх үүрэг хүлээн авч, тархвар судлалын ерөнхий тандалт, эрүүл мэндийн менежментийн зорилгоор өвчний олон улсын ангиллалыг хэд хэдэн удаа шинэчилж, нарийвчлалыг сайжруулсан [2]. АНУ-д 1917 онд хэвлэгдсэн "Хүний халдварт өвчинтэй тэмцэх" лавлах номын 1-р хэвлэлд 38 нозологийн хэлбэрийг ялган тогтоосон байдаг [3]. Монгол орны хувьд эрдэмтэн мэргэд эртнээс Энэтхэг, Төвөдөд гардаггүй боловч Монголчуудад тохиолддог өвчнийг хий, шар, бадганы онолд нийцүүлэн шинээр тогтоож өөрсдийн онцлогт тохирсон өвчний ангиллыг шинэчлэн боловсруулж хэрэглэсэн байна. Үүний нэг тод жишээ бол судар бичигт халдварт өвчний ангилал, нэршил, оношилгоо, эмчилгээг цоо шинээр системчилсэн баримт нотолгоо олон байдаг [4,5]. Иймд бид энэ чиглэлийн судалгааны жишээ болгож халдварт өвчний ангиллын талаарх түүхэнд холбогдох зарим эх сурвалж, баримтууд, анагаах ухааны ном судрыг судлан судалгааны эргэлтэд оруулах, сургалт, судалгаанд ашиглах, олны хүртээл болгохоор энэхүү сэдвийг сонгон авлаа.

Зорилго

Анагаах ухааны эртний судар номд халдварт өвчнийг хэрхэн ангилж байсныг судлан тогтоох. Засаж хасав

Хэрэглэгдэхүүн ба арга

Нэг. Судалгааны үндсэн хэрэглэгдэхүүнд дараах анагаах ухааны эртний судар номыг ашиглав. Үүнд:

1. Ламын гэгээн Лувсанданзанжанцан. “Хамба номун ханы буман зарлигаас увдист рашааны цацрал хэмээх оршвой”. Төвөд хэлээр Wylie галиг: Mkhan chen chos kyi rgyal po'i gsung 'bum las man ngag bdud rtsi zegs ma bzhugs so. Энэ ном 9х50см хэмжээтэй 19 хуудастай монгол модон барын төвөд.
2. Жамбалчойжиданзанпэрэнлэй. “Увдисын далай”. Боть 19. Орчуулсан Ш.Болд, Х.Улаан-Од, Д.Шагдарсүрэн. УБ, 2023
3. Сүмбэ хамба Ишбалжир. “Дөрвөн рашаан”. Монгол бичгийн гар бичмэл ном.

Хоёр. Судалгааны ажлын арга

- Эх бичиг судлалын арга

Бид судалгаанд ашигласан материалаа ажлынхаа зорилго, зорилтуудад нийцүүлэн зохиогчийнх нь төрсөн болон амьдарч байсан цаг хугацааг хамгийн эрт үеэс нь эхлэн эрэмбэлж, сурвалж бичгийн эх,

нэр, зохиогч, газар орон, онцлог, агуулга, тайлбар, хөрвүүлгийн судалгааг хийж улмаар бүтээлийн гол агуулга, сэтгэлгээний хувьд онцгой шинэлэг санааг бусад эх зохиолуудтай харьцуулан, шүүн тунгааж үзэв [17].

- Магадлан жагсаах арга

Магадлан жагсаах буюу хяналтын хуудасны арга нь уламжлалт анагаах ухаан дахь халдварт өвчинтэй холбоотой мэдээллийг төрөлжүүлэн жагсааж, тэдгээрийг тодорхойлсон хэсгийг тогтоох арга юм. Магадлан жагсаах арга нь мэдээллийг төрөлжүүлж ангилахад, өгөгдөл цуглуулахад хялбар, цахим санд оруулахад хялбар байдгаараа халдварт өвчний талаарх мэдээллийн сан бүрдүүлэх үндэс болсон [18].

Үр дүн

“Анагаах ухааны дөрвөн үндэс”-ийн “Увдисын үндэс”-т: “Нян хижиг өвчний бүлэгт шалтгаан, нөхцөл, орох үүд, шинж тэмдэг дээр үндэслэн ерөнхий ба тусгай гэж хуваагаад 4 бүлгээр өгүүлсэн. Үүнийг Дэсрид Санжаажамц “Манаг Лхантав” номд 18 бүлэг болгон ангилж нийт 22 халдварт өвчин болгосон [6].

"Анагаах ухааны дөрвөн үндэс"-д нян, хорхой өвчнийг хий, шар, бадган, цусны гэсэн 4 зүйл байна гэжээ. Түүнчлэн уг өвчнийг ангилахдаа "Халдварт хижиг"-т "хий хижиг, шар хижиг, бадган хижиг, хурмал хижиг, нян хижиг", XVIII зууны үеийн "Эрдэнийн эрхэс зуун анхаарлын бичиг оршвой"-д нянгийн 4 шинэ өвчнийг нэмээд 15 зүйл болгон дэлгэрүүлжээ. "Лхантав"-д "шар судалд гүйсэн хижиг, дотор боом, нян шил татах өвчин, битүү нян өвчин зэрэг шинээр 5 өвчнийг нэмж 20 зүйл болгон ангилж байжээ [7].

Тиймээс энэ чиглэлд ихээхэн хувь нэмэр оруулсан, энэ талын мэдлэгийг шинэчлэн боловсруулах ажлыг хийсэн монгол эмч, маарамбуудын бүтээлийг гүнзгийрүүлэн, хамрах хүрээг өргөтгөн судлах асуудал чухлаар тавигдаж байна. Ингэж уламжлалаа эргэн харж, өвөг дээдсийнхээ үлдээсэн мэдлэгийн их санг судлан, үнэт зүйлийг нь тодруулснаар цаашид уг уламжлалт анагаах ухааныг зөв, оновчтой хөгжүүлэх үндсийг баттай болгох, орчин цагийн анагаах ухаантай оновчтой хослуулан хөгжүүлэх учиртай юм [8].

1. Ламын гэгээн Лувсанданзанжанцан “Хамба номун ханы буман зарлигаас увдист рашааны цацрал хэмээх оршвой” судар дахь халдварт өвчний ангиллыг нэгтгэн шинээр тогтоожээ.

1. Хий хижиг
2. Нян хатгалга
3. Эс боловсорсон нянтай халуун
4. Нян боом
5. Улаан нүд
6. Нян өвчин
7. Тархины хатгалга (Нян тархинд бууснаас үүснэ)
8. Сахуу (Нян хоолойд бууснаас үүснэ)
9. Охор хатгалга (Нян цээжинд бууснаас үүснэ)
10. Ходоодны цанх (Нян ходоодонд бууснаас үүснэ)
11. Гэдэсний хатгалга
12. Гал намс
13. Булчирхай хавдах (Нян хүзүүний үенд бууснаас үүснэ)
14. Гадар боом
15. Дотор боом
16. Эрээсэн боом (Өргөс хатгасан зэрэг нь эрээснээс үүснэ)
17. Чийх (Нян мах ясанд бууснаас үүснэ)
18. Шил татах (Нян нугасанд бууснаас үүснэ)
19. Цөс судсанд гүйх (Нян цөсөнд бууснаас үүснэ)
20. Аргацаал /арга үгүй/ үгүй нян (Нян самсэд бууснаас үүснэ)
21. Ганцаар тэнэгч нян (Эгэм хавиар нян бууснаас үүснэ)
22. Овгор товгор нян (Биеийн аль нэг хэсэгт нян бууснаас үүснэ)

23. Чихээр хатгах (Нян чихэнд орсноос үүснэ)
24. Намарс (Нян шартай хавсран хийгээр хөлөглөж бүх биед тархсанаас үүснэ [9].

2. Жамбалчойжиданзанпэрэнлэйн "Увдисын далай" сударном нь өнөөгийн мэдлэгийн хэрээр бидэнд олдож байгаа Монголын уламжлалт анагаах ухааны эм найрлагын судлалын хамгийн том, иж бүрэн зохиол болно. Жамбалчойжиданзанпэрэнлэй "Увдисын далай" сударт: "Нүдний хижиг", "Нян өвчин шар, хийд урвасан", "Нян цөгц яр", "Нян хорхойт хөхөрч харлах", "Нян ёлом", "Нян толгойн хавдар" гэх мэт хижиг өвчнийг шинээр илрүүлж, улмаар "Бодоо хижиг", "Улаан нуд", "Дагшуур" зэрэг өвчнийг нян хижигт оруулснаар нийт 30 зүйлийн нян хижиг өвчин буй гэж дэлгэрүүлжээ. Мөн тэр бээр боловсорсон ба дэлгэрсэн халуун хоёрыг ялгаатайгаар өгүүлснээс гадна нян өвчнийг 27 зүйлээр дэлгэрэнгүй тэмдэглэсэн байна [10]. Бид судалгааны явцад 30 болгон дахин тоолж тогтоосон. Үүнд:

1. Нян хижгийг ерөнхийд нь анагаах нь
2. Нян өвчний ялгаа, гурван хар хуйларсныг анагаах арга
3. Шил татах өвчний эмчилгээ
4. Цөс судалд гүйснийг анагаах арга
5. Нян өвчин цул саванд буусан дотор боомын эмчилгээ
6. Тархины хатгалгыг засах арга
7. Нүдний хижгийг засах арга
8. Чихний судалд үлээгдсэнийг анагаах нь
9. Сахууг засах нь
10. Боомыг анагаах арга
11. Охор хатгалгын эмчилгээ
12. Нян цанхыг анагаах нь
13. Гэдэсний хатгалгын эмчилгээ
14. Нян гэмэд[1] өвчнийг засах арга
15. Нян булчин урвахыг анагаах нь
16. Нян булчирхай өвчний эмчилгээ
17. Нян гал намсыг анагаах нь
18. Нян ганцаар төрөгчийг анагаах арга
19. Овгор, товгор нянг анагаах арга
20. Нян өвчин шар хийд урвасныг анагаах арга
21. Нян цөгц ярыг анагаах арга
22. Нян элгэнд унасан өвчнийг анагаах арга
23. Нян хорхойт хөхөрч харлах өвчний эмчилгээ
24. Нян ёлмыг анагаах арга
25. Нян толгойн хавдрын эмчилгээ
26. Нян амрууг анагаах арга
27. Бодоо хижгийг анагаах арга
28. Бэнхээг анагаах арга
29. Томуу дагшуурыг анагаах арга
30. Дагшуур уушгинд шургасныг анагаах арга

3. Сүмбэ хамба Ишбалжир (1704-1788) анх түрүүн «Рашааны Цагаан шүүдэр» гэх зохиолдоо өвчний ялгалыг дотор өвчин, халуун өвчин, халдварт өвчин, таван эрхтний өвчин, цул,савын өвчин. эмэгтэйчүүдийн өвчин, нялхсын өвчин, хэсэн бусаг өвчин, хамт төрсөн яр, ил шарх, этгээд өвчин хийгээд хордлого зэрэг 13 их салаа хэсэгт хувааж түүний дотор бас бага салаа салбарт хувааж ангилжээ. Сүмбэ хамба Ишбалжирын "Рашааны цагаан шүүдэр" сударт халдварт өвчнийг дараах байдлаар ангилан бичжээ.

1. Бодоо өвчин (Цагаан цэцэг)
2. Дагшуур
3. Нян өвчин
4. Тархины хатгалга
5. Сахуу
6. Охор хатгалга
7. Ходоодны цанх
8. Гэдэсний хатгалга
9. Гал намс
10. Булчирхай хавдах
11. Булчин урвах

1 Төвөдөөр ma mo ngam nag хямарснаас үүсдэг нянгийн өвчин.

12. Гадар боом
13. Гал боом
14. Дотор боом
15. Эрээсэн боом
16. Чийх
17. Шил татах
18. Цөс судсанд гүйх
19. Аргацаал /арга үгүй/ үгүй нян
20. Ганцаар тэнэгч нян
21. Овгор товгор нян
22. Чихээр хатгах
23. Намарс [11]

Мөн түүнчлэн дээрх судар бичигт халдварт өвчнийг ангилахдаа баримталж байсан зарчим, үндэслэлийг зарим халдварт өвчнөөр жишээ болгон судлан тогтоов. Үүнд:

Өвчин аль эрхтэн системийг гэмтээж байгааг харгалзан ангилах.

1. Гал намс (гал хавдар) өвчин - Арьсны бүх давхарга гэмтэж, зэргэлдээх хэсгээсээ эрс ялгарсан улайлт үүсгэдэг өвчин.
2. Намарс - Арьсны дээд хоёр давхрыг хамран өвчлүүлдэг шүүдэст үрэвсэл. Намарс нь арьсны харшилт үрэвсэл юм. Үрэвсэлд өртсөн арьс хуурайшиж улайсан байх бөгөөд маш их загатнана.
3. Улаан нүд нь ихэвчлэн цочрол, үрэвсэл, халдварын улмаас нүдний цагаан хэсэгт (склера) улайлтаар тодорхойлогддог нийтлэг өвчин юм.
4. Гэдэсний хатгалга (гэдэсний халдварт үрэвсэл) нь ихэвчлэн нарийн, бүдүүн гэдэсний цочмог үрэвсэл. Шинж тэмдэгт гэдэс базлах, суулгах, бөөлжих, халуурах, хоолны дуршил буурах зэрэг орно.

Халдварт өвчнийг үүсгэгчээр нь оноож нэрлэн ангилах.

1. Хижиг - Нянгаар түргэн халдварладаг халдварт халуун өвчин: хижиг тусах (халдварт халуун өвчин тусах), гэдэсний хижиг (гэдэсний халдварт өвчин), бэжрүүт хижиг (биед бэжрүү туурах халдварт өвчин), хижиг тахал (нянгаар халдварладаг гоц халдварт өвчин.
2. Нян өвчин - Нян өвчний ерөнхий шалтгаан нь цусан улаан өнгөтэй, хөлгүй бөөрөнхий хорхой биеийн тамирыг идсэнээс болно. Нян өвчинд долоон зүйл байх бөгөөд бүгд цахилгаан мэт хортой юм.
3. Нян хатгалга
4. Эс боловсорсон нянтай халуун
5. Дагшуур - Шалтгаан нь ерийн хижиг лугаа адил. Нөхцөл нь бузар буртаг, халдварт хөлс зэргийг үнэртэх, айж цочих, нойр тэнцвэргүй болох, хүйтэн ус их уусан зэргээс болно.
6. Сахуу – Амьсгалын замаар халддаг өвчин. Шалтгаан нь нян хоолойд бууснаас үүснэ. Шинж нь хэлний өнгөр зузаарах, тагнайн мухарт бэржийх, хоолой сөөх, идээ ундааг залгихад бэрхшээх зэрэг болно.
7. Охор хатгалга - Нян цээжинд бууснаас үүснэ
8. Ходоодны цанх - Шалтгаан нь нян ходоодонд бууснаас үүснэ. Нөхцөл нь идээ эс шингэсэн, хөлөрсний дараа даарсан, ад зэргээс болно.
9. Нян боом гэх мэтээр нян буюу өвчин үүсгэгч хаана байршиж аль эрхтэн өвчлүүлж байгаагаар ангилж байжээ.

Хэлцэмж

Европын анагаах ухаанд НТӨ IV зуунд Грекийн эмч Гиппократын дэвшүүлсэн өвчний гол шалтгаан нь өвчтөний хүрээлэн буй орчноос үүдэлтэй, хортой муу агаартай (Грек μίασμα – миазма - бохирдол) холбоотой үүсэн тархдаг гэсэн Миазмын онолыг XIX зууныг хүртэл баримталж байсан [12]. Өвчин эмгэгийг системтэйгээр ангилах анхны оролдлогууд 1600 - 1700-аад онд хийж байсан боловч өвчний нэр томьёоны зөрчил, статистикийн мэдээлэл хомс байсантай холбоотой амжилт олоогүй байсан үед Монгол эрдэмтэн мэргэд өвчний

үүсгэгч, эмнэл зүйн шинж тэмдэг, гэмтээж буй эрхтэн системээр ангилан судалж байжээ [13]. АНУ-д 1917 онд хэвлэгдсэн "Хүний халдварт өвчинтэй тэмцэх" лавлах номын 1-р хэвлэлд 38 нозологийн хэлбэрийг ялган тогтоосон байдаг [14].

Бидний судалгаа хийсэн судар номд бичсэн ангиллаас үзэхэд “Анагаах ухааны дөрвөн үндэс” номын онол, арга зүйн үндэс нь эртний Энэтхэгийн Аюурведийн анагаах ухааны их гурвал зохиол тухайлбал “Найман гишүүнтийн зүрхний хураангуй” бүтээлээс гаралтай учраас халдварт өвчний ангилал нь ойролцоо байна.

“Анагаах ухааны дөрвөн үндэс”-т “Нян өвчин цусны оронд орших зэс мэт нарийн болоод үл үзэгдэх хорт хорхойгоос үүснэ.” Хий, шар, бадганыг хураасан үүсгэгч нь орон, цаг, идээ ундаа, явдал мөрийн нөхцөлөөр хорхой хямарч биеийн тамирыг идэн нян болно” гэж өгүүлжээ [15]. “Анагаах ухааны дөрвөн үндэс” судрын “Увдисын үндэс”-ийн тайлбар, Дэсрид Санжаажамцын “Манаг Лхантав” номд: “Нян өвчин нь нэг зүйлийн хумх хорхойгоос үүсдэг гэж үзээд хумхын хорхой нь гүрвэл мэт толгойтой, гэгээ завсрын орноос шар үсэнд үсний нүх ба хамрын үүдээр орно. Биеийн дотор буй агч хорхой нь улаан өнгөтэй, хөлгүй бөөрөнхий бөгөөд жижиг нарийн, хүний нүдэнд үзэгдэхгүй, нэгэн агшинд судлын дотуур бүх биед гүйж чаддаг цусны хорхойтой хамт оршиж, хамаг нян өвчний шалтгаан болдог” гэжээ [16]. Үүнийг тодруулбал, гаднаас хорхой орж, биед оршиж байгаа дотоод хорхойн хамтаар нян өвчин үүснэ гэсэн утгатай юм. Бидний сонгон судалсан эх сурвалжид энэхүү үзэл баримтлалыг дэлгэрүүлэн тодорхой эрхтэн системийг сонгон гэмтээдэг ба халдварт өвчнийг үүсгэгчээр болон өвчний илрэх эмнэл зүйн шинж тэмдгээр нь оноож нэрлэн өвчнийг ангилдаг болох нь тогтоогдсон юм. Тиймээс хижиг өвчин гэдэг нь үндсэндээ ямар нэгэн нян хорхойгоор үүсгэгддэг болох нь тодорхой байна.

Дүгнэлт

Монголын бурхан шашны болон анагаах ухааны нэртэй зүтгэлтэн Ламын гэгээн Лувсанданзанжанцан “Хамба номун ханы буман зарлигаас увдист рашааны цацрал хэмээх оршвой”, Жамбалчойжиданзанпэрэнлэй “Увдисын далай”, Сүмбэ хамба Ишбалжир “Дөрвөн рашаан” судар номдоо халдварт өвчнийг тодорхой нян хорхой үүсгэдэг хэмээгээд нийт халдварт өвчнийг хижиг хэмээн тодотгон нэрлэжээ. Судалгаанд авсан халдварт өвчинтэй холбоотой сурвалжуудаас үзэхэд монгол эмч, эрдэмтэн лам нар халдварт өвчний талаарх мэдээ, баримтыг ихээхэн баяжуулжээ. Үүний зэрэгцээ Энэтхэг, Төвөдийн анагаах ухааны номуудад байхгүй Монголд олонтоо гардаг халдварт өвчнүүдийг шинээр нээн, халдварт өвчний ангиллыг баяжуулжээ.

Ном зүй

1. Sudha R. Raminani. The Editors of Encyclopaedia Britannica. https://www.britannica.com/topic/International-Classification-of-Diseases.
2. History of the Statistical Classification of Diseases and Causes of Death. Iwao M. Moriyama, Ph.D. Ruth M. Loy, M.B.E., Alastair H.T. Robb-Smith, M.D. 2011.
3. Park, W. H. Control of Communicable Diseases. New York. 1917, 30 pp
4. Болд Ш. Монголын анагаах ухааны түүх. Улаанбаатар, Адмон ХХК-ийн Хэвлэх үйлдвэр. 2006, х.248
5. Монголын уламжлалт анагаах ухааны эм найрлагын судлал. (Төслийн удирдагч академич Ш.Болд, академич Д.Цэрэнсодном) УБ, 2014, х.24
6. Khenrab Gyamtso. A Brief Introduction to Virulent Infectious Disease (Nyen-rim) in the Tibetan Medical Canon: Etiology, Diagnosis and Treatment. Webinar Dialogue Series: Encountering COVID-19: Perspectives from Tibetan Medicine. https://www.kundewellness.org/uploads.

7. Tawni Tidwel, Khenrab Gyamtso. Tibetan Medical Paradigms for the SARS-CoV-2 Pandemic. Asian Medicine 16 (2021) 89–127.
8. Дагвадорж Очирбат. Ламын гэгээн Лувсанданзанжанцангийн намтар, анагаах ухааны зарим зохиолын агуулга, онцлогийг тогтоох нь. Анагаах ухааны докторын зэрэг (Ph.D) горилсон нэг сэдэвт бүтээл. УБ, 2026, х.14-15
9. Ламын гэгээн Лувсанданзанжанцан. “Хамба номун ханы буман зарлигаас увдист рашааны цацрал” хэмээх оршвой.” Модон барын төвөд судар.
10. Жамбалчойжиданзанпэрэнлэй. “Увдисын далай”. Боть 19. Орчуулсан Ш.Болд, Х.Улаан-Од, Д.Шагдарсүрэн. УБ, 2023
11. Сүмбэ хамба Ишбалжир. “Дөрвөн рашаан”. Монгол бичгийн гар бичмэл ном.
12. John M. Last, ed. "A Dictionary of Public Health". miasma theory. Westminster College, Pennsylvania: Oxford University Press. 2007, ISBN 978-0-19-516090
13. Sudha R. Raminani. The Editors of Encyclopaedia Britannica. https://www.britannica.com/topic/International-Classification-of-Diseases
14. Park, W. H. Control of Communicable Diseases. New York. 1917, 30 pp
15. Анагаах ухааны дөрвөн үндэс. Орчуулсан Минжүүр гүүш. Модон барын монгол судар. 1727 он
16. Дэсрид Санжаажамц. “Манаг Лхантав”. Төвөд, тод үсгийн гар бичмэл монгол судар
17. Bowen, G. A. (2009). Document analysis as a qualitative research method. Qualitative Research Journal, 9(2), 27–40.
18. Patton, M. Q. (2015). Qualitative Research & Evaluation Methods (4th ed.). Sage Publications.

Танилцаж, нийтлэх санал өгсөн:
Академич Ч.Чимэдрагчаа
АШУД, профессор О.Баатархүү